



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

### Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,000 /таван мянга/ ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-т зөвшөөрсүгэй.

2. Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Эрдэнэс сольюшинс” ХК /Ц.Хүдэрмөнх/-д үүрэг болгосугай.

1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, харилцагч, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллах;

2/ Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг худалдан авч буй хөрөнгө оруулагчдын үүргийн гүйцэтгэлийг бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжинд барьцаа хөрөнгөөр хангаж ажиллах;

3/ Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн үндсэн төлбөр, үлдэгдэл, эргэн төлөлтийн талаарх мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд улирал тутам ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

